Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

# СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ОРЛОГО ШИМТГЭЛИЙН БАЙЦААГЧ ОРОСБАТ БАЯРМААГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин(биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1.“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах” ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 1.1 | **Арга хэмжээ** 1.1.Нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллага, түүнд ажиллагсдыг албан журмын даатгалд шинээр хамруулах | Шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчдын тоогоор | 72 ажил олгогч | 79 ажил олгогч | 51 ажил олгогч, 324 даатгуулагч албан журмын даатгалд шинээр хамруулсан. | 01-06 | 100% |
| 1.2 | **Арга хэмжээ** 1.2.Нийгмийн даатгалын “Хамралтыг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд сайн дурын даатгуулагчийг шинээр хамруулах | Сайн дурын даатгалд иргэдийг хамруулсан байна. | 69 иргэнтэй сайн дурын даатгалд хамруулах гэрээ хийх | 72 иргэнтэй сайн дурын даатгалд хамруулах гэрээ хийх | 48 иргэнийг сайн дурын сайн дурын даатгалд хамруулахаар гэрээ байгуулахад нь туслалца үзүүлж, хамруулсан. | 01-06 | 100% |
| 1.3 | **Арга хэмжээ** 1.3. Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийг сурталчлах, иргэд | Хуулийг сурталчилж, иргэд даатгуулагч мэдлэг, мэдээлэлтэй болсон байна. | Нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож, иргэд даатгуулагчдад мэдээлэл өгсөн байна. | 569 иргэнд мэдээлэл өгсөн байна. | 1 ажил олгогч,569 даатгуулагч,мөн өөрийн хариуцсан 628 ажил олгогчийн ня-бо нарт | 01-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даатгуулагчдад мэдлэг, мэдээлэл өгөх | | | | нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. | | |
| ***Зорилт 2:*** *"Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах"* **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад *чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1 | **Арга хэмжээ** 2.1.Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлэх. | Батлагдсан сангийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажилласан байна. | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатaлын сангийн орлогыг 33 140,1 сая төгрөгөөр буюу 108,4 % хувьтай биелүүлсэн. | Эхний хагас жилийн байдлаар 17 979,8 сая төгрөгийг биелүүлсэн байх. | Нийгмийн даатгалын шимтгэлийн өөрийн хариуцсан байгууллагуудын орлогыг 22 301,6 сая төгрөг болгож, орлогын төлөвлөгөөг 124,0 хувиар давуулан биелүүлсэн. | 01-06 | 100% |
| 2. | **Арга хэмжээ** 2.2. Ажил олгогчоос сар бүр ирүүлж буй нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар хүлээн авах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. | Үйл ажиллагааны хэрэгжилтийн байдлаар | 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 577 аж ахуй нэгж байгууллагын тайланг хүлээн авч ажилласан. Үүнээс 137 ажил олгогчийн тайланг тоон гарын үсгээр, 440 ажил олгогчийн тайланг цахимаар хүлээн авч ажилласан. | 577 аж ахуйн нэгжийн тайланг хүлээн авснаас: 17 ажил олгогчийн тайланг тоон гарын үсгээр, 440 ажил олгогчийн тайланг цахимаар хүлээн авах. | Сар бүр давхардсан тоогоор 628 ажил олгогчийн тайланг шинэ системээр хүлээн авч мэдээллийн санд оруулан ажилласан. | 01-06 | 100% |
| 3 | **Арга хэмжээ** 2.3.Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах талаар нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж оны эхний үлдэгдлээс бууруулах, үр дүнг зохих газарт хүргүүлэх | Ажил олгогоос төлөх шимтгэлийн авлагыг бууруулсан байна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлага 4 749,5 сая төгрөг байна. | 10 хувь бууруулсан буюу 4 274,6 төгрөг болгосон байна. | Хуримтлагдсан авлагын хэмжээ насжилтыг тодорхойлсон судалгааг гарган, тайлан шимтгэлийн авлага барагдуулах журмын дагуу арга хэмжээг шат дараалан авч ажилласан. Оны эхний авлага 4 749,5 сая төгрөг байснаас 99 ажил олгогчийн 1101,8 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж, 49 ажил олгогчийн 311,9 сая төгрөгийн авлагыг хэсэгчлэн барагдуулж ажилласан. 179,8 сая төгрөгийн өртэй 9 ажил олгогчид улсын байцаагчийн | 01-06 | 95,8% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | албан шаардлага хүргүүлж, 618,9 сая төгрөгийн өртэй 9 ажил олгогчийн арилжааны банкин дах харилцах дансны зарлагын гүйлгээг хааж, 189,7 сая төгрөгийн өртэй 5 ажил олгогчтой авлага барагдуулах гэрээг байгуулан ажилласан. Мөн 1 байгууллагын 89,5 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд шилжүүлэн бүрэн барагдуулсан, 14 байгууллагын хаягийг тодруулахаар эрэн сурвалжлахад шилжүүлэн 9 байгууллагын шүүхийн шийдвэр гарсан. | | |
| 4 | **Арга хэмжээ** 2.4.Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээг 13.0 хувиас хэтрүүлэхгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээ 10,9 % байна. | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага бууруулах, 13.0 хувиас хэтрүүлэхгүй байх. | 2024 оны эхний хагас жилийн байдлаар орлогод эзлэх авлага 18.5 % буюу 5 879,5сая төгрөгийн шимтгэлийн өртэй байна | 01-06 | 89,4% |
| 5 | **Арга хэмжээ** 2.5.Өөрийн хариуцаж буй ажил олгогч байгууллагуудтай холбоотой Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжсэн шимтгэлийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, арга хэмжээ авах | Барагдуулсан дүнгээр | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд өгсөн өртэй байгууллагуудын өр буурсан байх. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд өгсөн өртэй байгууллагуудын 50 хувь өр барагдсан байх. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд өгсөн өртэй байгууллага Молгол глобал ХХК – ний 89,9 сая төгрөгийн өрийг бүрэн барагдуулж ажиллаа. | 01-06 | 100% |
| 6 | **Арга хэмжээ** 2.6. Хяналт мониторингийн программд зөрчлөөр бүртгэгдсэн ажил олгогчийн болон даатгуулагчийн цалин, үндсэн мэдээлэлд залруулга хийх; | Мэдээллийн бааз дахь даатгуулагчийн үндсэн мэдээлэл, цалинд залруулга хийж, зөрчил арилсан байна. | Зөрчил үүссэн тоогоор | Зөрчил үүссэн тоогоор | Мэдээллийн бааз дахь даатгуулагчийн үндсэн мэдээлэл, цалинд залруулга тухай бүрт нь хийж ажиллаж байна | 01-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Зорилт 3. “Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1.** Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг биелүүлэх | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх, журамд заасны дагуу үнэлгээний багийн даргаар ажиллаж зохих журмын дагуу албан үүргийг гүйцэтгэх | Т Сангийн бусад өглөг /2024 он/ - ийн барагдуулалт, залруулга хийсэн баримтын бүрдүүлэлтийг нэг бүрчлэн шалгаж, шалгалтын үр дүнг Хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар өрийн албан хаагчийн хуралдуулах, дүгнэлт гаргах | 2023 оны жилийн эцсийн байдлаар ажил олгогчоос илүү төлсөн шимтгэл 3 147,8 сая төгрөг, ЭМДаатгалын сангийн- 21,9 сая төгрөг илүү төлсөн шимтгэлийн үлдэгдэл нийт 3 169,7 сая төгрөг байна. | 2024 оны эхний хагас жилийн байдлаар 5 даатгуулагчийн 11,8 сая төгрөгийн илүү төлсөн шимтгэлийн тооцооллыг хийж санхүү бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч шийдвэрлэсэн. | 01-06 | 100% |
| 2. | **Арга хэмжээ 3.2.** Төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой бусад хууль тогтоомжийн холбогдох хэсгүүдийг биелүүлэх | -Архив албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллах, архивын материалыг цаг хугацаанд нь хүлээлгэн өгөх<br>-Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх<br>-Хувь хүний мэдээллийн нууцийн хуулийн дагуу нууцлах, хэрэгжүүлэх | -Өөрийн хариуцсан ажлын баримтыг журмын дагуу архивын нэгж болгон хугацаанд нь зохих албан тушаалтанд хүлээлгэн өгөх<br>-Хуулиар тогтоосон хугацаанд ХАСУМ, ХАСХОМ-ыг гаргаж өгөх<br>-Албан ажлын шугамаар олж мэдсэн хувь хүний мэдээллийг задруулахгүй ажиллах | Хариуцсан ажлын чиглэлээр материалыг архивт зохих журмын дагуу хүлээлгэн өгөх<br>-Өөр албан тушаалд шилжин томилогдсон тохиолдолд ХАСУМ гаргаж өгөх, ХАСХОМ-ыг хуульд заасан хугацаанд нь гаргаж өгөх<br>-Албан ажлын шугмаар олж авсан хувь хүний нууцийг нууцлах | Өөрийн хариуцсан 2023 оны ажил олгочдын НД-7,НД-8 маягт баримтыг журмын дагуу 668 архивын нэгж болгон хугацаанд нь үдэж дугаарлан зохих албан тушаалтанд хүлээлгэн өгсөн.<br>-Хуулиар тогтоосон хугацаанд 2024 оны ХАСУМ, ХАСХОМ-ыг гаргаж өгсөн. | 01-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Хариуцсан ажлын хүрээнд өргөдөл гомдол, санал, албан бичигт хариу өгөх<br><br>-Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх | -Өөрийн хариуцсан ажилтай холбоотой асуудлаар хандсан өргөдөл, гомдол, албан бичигт хариу өгөх<br><br>-Удирдлагаас өгсөн хууль ёсны 4 удаагийн үүрэг даалгавар | - Ирүүлсэн өргөдөл гомдол, албан бичгийн тоогоор<br><br>-Удирдлагаас өгсөн хууль ёсны 2 удаагийн үүрэг даалгавар | 2024 оны эхний хагас жилийн байдлаар өөрт хандсан 38 албан хүсэлт,8 өргөдөл, гомдол хүлээн авч хариуцан шийдвэрлэлээ, | | |
| **Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| 2.1 | **Арга хэмжээ 1.** Мэргэжлийн ур чадвараа сайжруулах, дээшлүүлэх | Мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна. | Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх төрлийн сургалтад 2 удаа хамрагдсан байх | 1 удаагийн сургалт | Хүний нөөцийн чиглэлээр 2024.02.10-нд Удирдлагын академиас зохион байгуулсан 1 өдрийн сургалтад хамрагдсан. | 01-06 | 100% |
| 2.2 | ISO 9001:2015 олон улсын стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хэрэгжилтийг хангаж ажиллах | Санаачлан хийсэн ажил, хүрсэн үр дүнгээр | Санаачлан хийсэн ажил, хүрсэн үр дүнгээр | ISO 9001:2015 стандарт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | ISO 9001:2015 олон улсын стандартыг хэрэгжүүлж эхлэхтэй холбоотойгоор тасгийн өрөө тасалгааг цэцэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Дархан-Уул аймгийн НДГазраас туршлага судлан өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | 01-06 | 100% |

*Тайлагнасан:*

Орлого шимтгэлийн байцаагч ................/ О.Баярмаа/
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

..........................
*(огноо)*